



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШУУНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2021.03.12. № 04

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар захирамжаар байгуулагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Ажлын хэсгийн гишүүд Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, Баянгол дүүргийн Ахмадын эмнэлэг, Хүүхдийн эмнэлэг, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэгт дархлаажуулалтын ажлын явцтай газар дээр нь очиж танилцлаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1.Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж байгаа "Нэг өрх-Нэг шинжилгээ" тандалт, илрүүлгийн шинжилгээний явц, үр дүнгийн талаар;

2.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын нөхцөл байдлыг хяналтдаа байлгаж чадаж байгаа эсэх талаар;

3.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын вакцины захиалга, нийлүүлэлт, санхүүжилтийн талаар;

4.Иргэдийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эхний ээлжинд оруулж ирсэн 3 төрлийн вакцин /Спутник-V, Синофарм, Астразенека/-аас сонгож хийлгэх боломжоор хангах эсэх талаар;

5.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дархлаажуулалтын аяны үед ажиллаж байгаа эмч, сувилагч, ажилтнуудын цалин, урамшуулал, дархлаажуулалт хийхэд шаардлагатай урсгал зардлын санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар;

6.Дархлаажуулалт хийх чадамж бүхий хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг дархлаажуулалтын аянд оролцуулахдаа ард иргэдэд санхүүгийн дарамт үүсгэхгүй байхаар хэрхэн зохион байгуулах талаар;

2090000114




7.Хөдөө, орон нутагт амьдарч буй иргэдийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дархлаажуулалтад хэзээ, ямар төлөвлөгөөтэйгээр хамруулах талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т заасны дагуу Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮН,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.ЧИНБҮРЭН

Б.БАТТӨМӨР

М.ОЮУНЧИМЭГ

С.ОДОНТУЯА

Б.ЖАРГАЛМАА

Ж.СҮХБААТАР

2020000114